

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны  
98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ АЖИЛТАН Ж.САНДУЙЖАВЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	5		
1	2	3	4				6	7
<b>Зорилт 1. "АЙМГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОГДСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ" зорилтын хүрээнд:</b>								
1.1	Гадны ЭСЯ болон хөтөлбөрийн газруудтай холбоотой ажиллаж, төслийн мэдээллээр аймаг орон нутгаа хангах	Санал, мэдээлэл харилцан солилцсон, удирдлага мэдээллээр хангагдсан байх	100	Хэрэгжилт 90- аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	Эхний хагас жилд Герман, АНУ, ОХУ, Чех улсууд болон Европын холбооны Элчин сайд, ЭСЯ-ны газар, хэлтсийн ажилтнууд Орхон аймагт ажилллав: - Шинээр барьж ашиглалтад авсан Номын өргөөнд АНУ-ын ЭСЯ-тай хамтран "Америкийн соёл мэдээллийн төв"-ийг түшиглэн 2 удаа сургалт, мэдээллийн ажиллагаа зохион байгуулав. -Чех улсын Элчин сайд болон Чехийн Аялал жуулчлалын Дэд сайдаар ахлуулсан төлөөлөгчид Орхон аймагт ажиллаж удирдлагуудтай уулзан санал солилцож, манай аймгийн хог хаягдын менежменттэй танилцан цаашид хог шатаах том оврын зуух байгуулах асуудлаар санал тавьсан.Энэ төсөл нь Европын ЭКСИМ банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих боломжтой гэсэн мэдээлэл өгсөн. -Япон улсын Токамачи хоттой сурагч солилцооны хөтөлбөрийг эхлүүлж, б сургачийг шалгаруулсан бөгөөд тэд ирэх 9-р сараас Япон улсад очих юм.	2025.01.02 2025.06.30	70%	

					<p>-Тус улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хөтөлбөрийн газартай тогтмол мэдээлэл солилцож, өрсдийн хэрэгцээ шаардлагаа илэрхийлсэн 5 төслийг хүргүүлсэнээс БОЭТ-ийн төсөл эцсийн шатны хуралдаан орохоор шалгарсан.</p> <p>-Монгол-Оросын найрамдал хамтын ажиллагааны өдруүд, Эх орны дайны ялалтын өдөр зэрэг арга хэмжээнд 6,5 сая төг захирамжаар зарцуулж, Ерөнхий Консулын газар, Эрдэнэт үйлдвэртэй хамтран ажилласан.</p> <p>-Япон, АНУ, Унгар, Герман улсын ЭСЯ-дад хандаж, виз авах шаардлагатай удирдах ажилтнуудын цаг, мэдүүлэг зэргийг бүрдүүлэн хүргүүлсэн байна.</p> <p>- Европын холбооны Элчин сайд И.Марчёлюните хамтран хэрэгжүүлж байгаа "Гамшигт тэсвэртэй хот" төслийн хүрээнд үерийн даланг шинэчлэх ажлын нээлтийн ажиллагаанд оролцож аймгийн удирдлагуудтай уулзан санал солилцсон бөгөөд цаашид ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах боломж байгааг цохон тэмдэглэв.</p>		
1.2	Гадаадын хот, мужуутдтай цар тахлаас үүдэн тасалдсан харилцааг сэргээн хөгжүүлэх, шинээр гадаадын 1-2 хот, мужтай харилцан ашигтай хамтын ажиллагаа тогтоох	Харилцаа холбоо тогтоох хот, мужтай холбогдох, албан тоот солилц-сон, харилцан ойлголцолд хүрсэн байх	100	Аймгийн удирдлагууд мэдээллээр цаг тухай бүр хангагдаж, 1-2 хоттой шинээр найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай болсон байна.	<p>-БНСВУ-ын Даклак мужид болсон Аялал жуулчлалын эвент арга хэмжээ болох "Кофены фестиваль"-д ХБТХО-ын хэлтсийн С.Даваадорж дарга ахалсан төлөөлөгчид оролцсон.</p> <p>-Солонгос улсын Сунчон мужид манай аймгийн боловсролын салбарын төлөөлөгчид 4-р сард айлчлав.</p> <p>-АНУ-ын Фэйрбанкс, Турк улсын Эдреимит хотуудтай өмнө нь тогтоосон байсан харилцааг сэргээх асуудалд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг аймгийн Засаг даргаас Гадаад харилцааны яаманд илгээлээ.</p> <p>-Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан зарим улс, хотуудаас зочин урих асуудлаар албан тоот төлөвлөн хүргүүлэн ажиллав.</p>	2025.01.02 2025.06.30	70%

1.3	Аймгийн удирдлагууд болон төрийн байгууллагуудын төлөөлөгчдийн албан айлчлалд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, гадны зочдыг хүлээн авах бэлтгэл ажил хангаж, ёслолын арга хэмжээ зохион байгуулах	Аймгийн удирдлага болон гадны үйлчлүүлэгчдээс санал гомдол гарцаагүй байх	100	Хэрэгжилт 90-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	<p>Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр тэргүүтэй 4 хүний бүрэлдхүүнтэй төлөөлөгчид ОХУ-ын Буриадын Засгийн газрын тэргүүн А.Цыденовын урилгаар 2025 оны 5-р сарын 8-9-ний өдрүүдэд явагдсан Эх орны дайны ялалтын 80 жилийн ойн арга хэмжээнд хүндэт зочноор оролцов.</p> <p>-Аймгийн Засаг даргын орлогч Б.Мөнхдалай тэргүүтэй төлөөлөгчид 2025 оны 6-р сарын 13-14-ний өдрүүдэд Улаан-Үд хотын баярын үйл ажиллагаанд оролцоход зохион байгуулалтаар хангаж ажиллалаа. Энэ үеэр Улаан-Үд хотын Эдийн засаг соёлын өдрүүдийг Орхон аймагт 2025 оны 9-р сарын 3 дахь арав хоногт зохион байгуулахаар Санамж бичиг үзэглэсэн болно.</p> <p>-Аймгийн Төрийн аудитын газрын 14 хүний бүрэлдхүүн ОХУ-ын Улаан-Үд хотод 2025 оны 6-р сарын 26-28-ны өдрүүдэд ажлын туршлага судлах айлчлал хийхэд нь зуучлагчаар ажиллаж, хэлмээрчийн үүрэгтэйгээр Улаан-Үд хотод 3 хоног томилотгоор ажиллав.</p> <p>-Тайлант хугацаанд 3 орны ЭСЯ-ны удирдлага, гадны зочдыг хүлээн авах ажиллагааг "Амарын танхим"-д зохион байгуулан хөтөлж явуулсан.</p>	2025.01.02 2025.06.30	70%
1.4	Бие даан болон бусад агентлаг байгууллагатай хамтран 1-2 төсөл бичиж удирдлагад танилцуулах	Төсөл удирдлагын түвшинд танилцуулагдаж, дэмжигдсэн байх	100	Хэрэгжилт 90-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	<p>Аймгийн Хот тохижуулах газарт шаардлагатай цас хайлуулах бодис, материалын талаархи мэдээллийг ОХУ-ын зах зээлээс хэрхэн олж болох мэдээллийг тус газарт гаргаж өгөв.</p> <p>-Япон улсад суугаа Монгол улсын ЭСЯ-нд Орхон аймагт хэрэгцээтэй байгаа зарим техник төхөөрөмж, эд хогшлын судалгааг гарган хүргүүлэв.</p> <p>-Унгар улсын ЭСЯ-наас Европын холбооны ЭКСИМ /Экспорт импортын / банкаар дамжуулан 3 төслийг танилцуулахаар болов.</p>	2025.01.02 2025.06.30	50%

1.5	Аймгийн инноваци бүтээмжийн зөвлөлийн үйл ажиллагаанд санал өгөх эрхтэйгээр оролцох	Зөвлөлийн гишүүн байх	100	Хэрэгжилт 90-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	Инноваци бүтээмж, шилдэг төсөл шалгаруулах 2024 оны шалгаруулалтад шалгарсан хамт олны санхүүгийн баримтыг бүрдүүлж ажиллав. Зөвлөлийн бүрэлдхүүн шинэчлэгдэж миний хувьд тус зөвлөлд ороогүй болно.	2025.01.02 2025.06.30	30%
1.6	Инноваци , бүтээмж шингэсэн төслүүдийг шалгаруулах замаар дэмжлэг үзүүлж ажиллах	Шалгаруулалт явагдаж, төслүүд санхүүгийн дэмжлэг авсан байх	100	Хэрэгжилт 90-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	Хэрэгцээ шаардлага хангасан төслүүдийг дэмжих, санхүүжилт олгох үйл ажиллагаа ХБТХО-ын хэлтсийн шугамаар хийгдсээр байна. Нэгдсэн дүн мэдээ жилийн эцэст нэгтгэгдэнэ.	2025.01.02 2025.06.30	30%

**ХОЁР. “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:**

2.1	1 Хэлтсийн хариуцах чиглэлээр эрх бүхий гадаад дотоодын байгууллага, албан тушаалтан, иргэдээс шийдвэр гаргуулахаар болон дэмжлэг хүсэж тавьсан асуудлыг судалж шийдвэрлүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах	Үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан байна.	100	Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 50-аас доошгүй хувь биелүүлэн ажилласан байна.	Аймгийн төлөөлөгчдийн айлчлал, гадны зочдыг хүлээн авах төсөв зардлыг Сангийн сайдын 2011 оны 188-р тушаал болон аймгийн ИТХ-аас тухайн оны төсөв зардлыг зүйлчлэн баталсан тогтоолын хүрээнд төлөвлөн зарцуулдаг. Захирамж төлөвлөн батлуулах журмын хүрээнд хянагдаж шийдвэр болж гардаг. Гадны орны ЭСЯ-д болон олон улсын байгууллагаас төлөөлөгчид айлчлан ирсэн тохиолдолд уулзалтын тэмдэглэлийн нэг хувийг үүргийн дагуу Тагнуулын байгууллагад өгч ажиллаж байна. Үүргийн дагуу аймгийн ИТХ болон Засаг даргын 3 удаагийн айлчлалын үед ГХЯ-ны холбогдох газар, мэргэжилтнүүдээр дамжуулан зөвшөөрөл, ярианы сэдэв авч ажиллав.	2025.01.02 2025.06.30	70%
2.2	2.2 Олон нийтэд тустай мэдээллийг гадаад хэл, мэдээллийн давуу эх сурвалжаас олж		100	Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 50-аас доошгүй хувь биелүүлэн	Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийтийн сүлжээгээр Гадаад орны Их дээд сургуулиудад бүрэн болон хувь тогтоосон тэтгэлэгээр суралцах боломж, бүрдүүлэх материалтай холбоотой мэдээллийг 60 гаран	2025.01.02 2025.06.30	70%

	НИЙТИЙН БОЛГОХ	ХҮРТЭЭЛ			АЖИЛЛАСАН БАЙНА.	УДАА ТҮГЭЭЖ АЖИЛЛААА. ҮҮНД ОХУ, АНУ, БНХАУ, Австрали, Англи, Унгар, Чех, Болгар, Турк, Япон, Итали, Солонгос зэрэг орны сургуулиудын мэдээлэл, холбогдох хаяг, албан тушаалтны мэдээллүүд багтсан болно.		

**ЗОРИЛТ 3. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ зорилтын хүрээнд:**

Д/Д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	3.1 ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, холбогдох албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	100	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох газарт хүргүүлсэн байна.	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймагийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Таван жилийн үндсэн чиглэл, Тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулан Хэлтсийн даргаар хянуулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ж.Сандуйжав миний Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь нийт 3 зорилт хэрэгжүүлэх 13 арга хэмжээнээс бүрдэж байна. Хугацаанд нь тайлагнан ажиллав.	2025.01.02 2025.06.30	70%
2.	3.2 "Архив, албан хэрэг хөтлөлт" тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	100	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Архив, бичиг хэрэгт холбогдох материалыудыг хүлээлгэн өгсөн Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн	2025.01.02 2025.06.30	70%

	хууль болон нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.				ХЭМЖЭЭГ МӨРДӨН ЗӨРЧИЛ ГАРГААГҮЙ БОЛНО.		
3	3.4 Удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.	Удирдлагын зүгээс гомдол гараагүй байх	100	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжинэ.	<p>Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг чиг үүргийн болон чиг үүргийн бус гэсэн ялгамжгүйгээр цаг хугацаанд нь гомдол чирэгдэлгүй биелүүлэхийг хичээж ажиллав. Чиг үүргийн бус үүрэг даалгавар нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий сайд агсан А.Амарын хөшөөг сэргээн засварлах аж ахуйн нэгж – Автын кузов засварын газрыг олж Тамгын газрын даргад санал болгосон.</li> <li>- Эх орны дайны ялалтын 80 жилийн оид зориулсан ахмадууд, Орост дээд сургууль төгсөгчдийн аялалыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.</li> <li>-ОХУ-ын Боловсролын бичиг баримт баталгаажуулалтын газар болон Эрхүү хот руу Орхон аймгийн иргэн Г.Пүрэвсүрэн, Б.Эрдэнэбаатар нарын Их, дээд сургууль төгссөн дипломыг баталгаажуулах хүсэлт илгээн хариуг буцаан авч хүсэлт гаргасан иргэдэд хүлээлгэн өгсөн.</li> <li>Байгууллагаас баталсан хөдөлмөрийн дотоод журам, албан хаагчдын ёс зүйн дүрэм болон үйлчилгээний стандарт, TAX-ийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллаж байна.</li> </ul>	2025.01.02 2025.06.30	70%

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур Үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
<b>Зорилт 1.</b>							
1.	Шинээр батлагдсан хууль тогтоомжийг судалж, үйл ажиллагаандаа ашиглах.	Хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан сайжруулсан байна.			<p>“Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй танхимын болон зайн сургалтуудад хамрагдаж байна. Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлт - тэй зээлийн үйлчлэлээр орж ирэх бараа үйлчилгээг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх журмыг сурталчилсан онлайн сургалт, А-3-ын сургалтад хамрагдан гэрчилгээ авсан. Сангийн сайдын Гадаад томилолтыг зохицуулах журамд өөрчлөлт орсоныг ажилдаа мөрдөн ажиллаж байна.</p>	2025.01.02 2025.06.30	70%
2.	Хуучин монгол бичгийн чадвараа дээшлүүлэх	Чадвар ахисан байна.			Хуучин монгол бичиг огт мэддэгтүй байсан бол үсэг тогтоож, үсэглэн уншдаг болсон.	2025.01.02 2025.06.30	70%

**ТАЙЛАН ГАРГАСАН: Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Инноваци, бүтээмж, төсөл хөтөлбөр хариуцсан ахлах ажилтан**

Ж.САНДУЙЖАВ

2025.06.09